



“ХҮЧИН БҮРЭН” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ-д

СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: (976)-7036-3653

2023.10.18 № 647
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Танай компаниас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 43/2023 тоотоор ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 1-р багийн нутаг дэвсгэр Сөдтэй нэртэй газар төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй “Хүчинбүрэн” ХХК нь 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд санал авах хүсэлт ирүүлжээ.


Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.4, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.5, 9.10 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах тухай журам”-ыг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

Журмын 4.1-д төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор тус газарт ирүүлэхээр заасан байдаг.

Иймд тайлан ирүүлэх хугацаа болсон тул орчны цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж бий болгох, “Тэрбум үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд ойг нөхөн сэргээх, ойжуулах ажил Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар албан даалгаврын 4 дэх хэсэгт заасны дагуу био болон боловсон жорлон бий болгох ажлуудыг төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатайг анхаарна уу.

Хувийг: Хүдэр сумын Засаг дарга,

ДАРГА



З.ТҮВШИНТӨГС

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл	2
1.2. Төслийн байршил	2
1.3. Баяжуулах цехийн хүчин чадал, ажиллах горим	4
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
4.1. Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	10
4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
1.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	13
1.2 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .	13
1.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	13
1.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
1.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	14
1.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
1.7 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	16
1.8 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	19
1.9 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.	19
БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Төмөртэйн гол”-ын төмрийн хүдрийн уурхайн баяжуулах үйлдвэрийн хаягдлыг түшиглэн байгуулах “Хаягдал төмрийн хүдрийг дахин баяжуулах цех” төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Улсын бүртгэлийн гэрчилгээ: Регистрийн дугаар :	“Хүчин Бүрэн” ХХКомпани 9019073106 57200818
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, БГД, 1-р хороо, Жонбээс ХХК-ийн байр, 304 тоот Харилцах утас: 99221117, 99068196


1.2. Төслийн байршил

“Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” нь Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт М-48-83 планшетад, Улаанбаатар хотоос зүүн хойш 400 км-т байрлана. Хүдэр сумын нутаг дэвсгэр нь баруун талаараа Сэлэнгэ аймгийн Ерөө сумтай, баруун хойд талаараа Алтанбулаг сумтай, хойд талаараа ОХУ-тай тус тус хиллэдэг.


Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

№	Уртраг			Өргөрөг			UTM	
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	X	Y
1	107	13	16.97	49	42	53.96	660132.475	5509311.195
2	107	13	25.98	49	42	55.03	660311.899	5509349.577
3	107	13	29.56	49	42	48.57	660389.491	5509152.221
4	107	13	15.4	49	42	48.22	660106.283	5509133.018
5	107	13	16.28	49	42	49.87	660122.396	5509184.490
6	107	13	19.06	49	42	50	660177.941	5509190.151
7	107	13	18.19	49	42	51.64	660159.022	5509240.278

Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршил



Зураг 2. “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр”-ийн барилга



Зураг 3. Төслийн талбайн орчны төлөв байдал



1.3. БАЯЖУУЛАХ ЦЕХИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ

Баяжуулах цех 10 жилийн хугацаанд ажиллах бөгөөд жилд дунджаар 130 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай байхаар төлөвлөсөн байна. Баяжуулах цех нь улирлын чанартай ажиллах бөгөөд бусад ижил төстэй цехүүдийн жишгээр хавар 4-р сарын эхнээс намар 10-р сарын эцэс хүртэл хүдэр боловсруулах үйл ажиллагаагаа явуулаад өвөл нь борлуулалттай холбоотой үйл ажиллагаагаа явуулна.

Хүснэгт 2. Баяжуулах цехийн хүчин чадал, төлөвлөлт

№	Ашиглалтын жилүүд	Таваарын хүдэр дэх			Таваарын хүдэр, тн
		Fe, %	P, %	S, %	
1	2023	38,74	0.08	0.06	65000
2	2024				130000
3	2025				130000

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хүснэгт 3. Баяжуулах цехийн бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Агуулга %	Гарц %	Металл авалт,%	бүтээгдэхүүн, тн	металл. тн
Боловсруулах хүдэр					
1 дэх жил	38.74	100	100	65000	25181
2 дах жил	38.74	100	100	130000	50362
3 дах жил	38.74	100	100	130000	50362
4 дах жил	38.74	100	100	130000	50362
5 дах жил	38.74	100	100	130000	50362
6 дах жил	38.74	100	100	130000	50362
7 дах жил	38.74	100	100	130000	50362
8 дах жил	38.74	100	100	130000	50362
9 дах жил	38.74	100	100	130000	50362
10 дах жил	38.74	100	100	130000	50362
Нийт	38.74	100	100	1235000	478439
Баяжмал					
1 дэх жил	67.33	53.61	93.18	34847	23463
2 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
3 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
4 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
5 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
6 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
7 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
8 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
9 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
10 дах жил	67.33	53.61	93.18	69693	46926
Нийт	67.33	53.61	93.18	662084	445797
Хаягдал					
1 дэх жил	5.7	46.39	6.82	30153	1718
2 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
3 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
4 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
5 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
6 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
7 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
8 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
9 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
10 дах жил	5.7	46.39	6.82	60307	3436
Нийт	5.7	46.39	6.82	572916	32642

**БҮЛЭГ 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН
ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

№	Байгаль орчны бүрдэл	Товч тайлбар
1	Физик газарзүйн нөхцөл	Төсөл хэрэгжих талбайн байршлыг физик газар зүйн хувьд авч үзвэл Хан Хэнтийн нурууны хойт хэсэгт Хүдэр голын сав газарт оршдог бөгөөд газар хөдлөлтийн сул бүсэд хамрагддаг байна. Мөн далайн түвшнээс дээш 1100 метр өргөгдсөн. Хүдэр, Шоргоолж, Өндөр цагаан, Сэлэм хайрхан, Шүдэт уул, Алаг давааны нуруу зэрэг олон уул нуруудтай. Сумын нутаг дэвсгэрийн 61.8 хувийг ой мод эзэлдэгээс хангайн болон тайгын бүслүүрийн шилмүүст, навчит ойд 10 гаруй төрлийн мод ургасан үзэсгэлэнт уул нуруудтай, төрөл бүрийн ан амьтан, жигүүртэн шувууд тархсан, ашигт малтмалын болон байгалийн баялаг ихтэй бүс нутаг юм.
2	Цаг уур уур амьсгал	Сэлэнгэ аймгийн бүс нутгийн цаг агаар нь хүйтэн, чийглэг эрс тэс уур амьсгалтай, хавар намартаа салхи ихтэй, зуны эхэн сардаа бороо их орж, өвлийн улиралд хүйтэн байдаг. Чийглэг уур амьсгал зонхилсон. Зундаа +28 0С халуун, өвөлдөө -39 0С хүйтэн байдаг ба I сарын дундаж температур -41 0С, VII сарын дундаж температур +26 0С байдаг. Жилийн дундаж температур 14.2°С, хамгийн доод температур -38.9°С, хамгийн дээд температур +33.6° С. Тус сумын нутаг нь далай тэнгисээс алслагдсан байршилтай, гадаргын тогтоц, өндөршилт, агаарын ерөнхий орчил урсгал зэрэг хүчин зүйлээс шалтгаалан эх газрын эрс тэс уур амьсгалтай. Өвөлдөө -25 0 -(-32 0)С, зун 22 0 – 30 0С. Хүйтрэлтгүй дулааны өдрийн тоо дунджаар 88-95 хоног үргэлжилдэг. Агаарын жилийн дундаж температур нутгийн хойд хэсгээр -2 0 -4 0С , өмнөд хэсгээр -2 0 - 0 0С байна.
3	Гадаргын ус	Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутаг дэвсгэр нь гадаргын усан сүлжээний хувьд Умард мөсөн далайн ай савд хамаарагддаг байна. Сумын хойд хэсгийг Цөх, Хүдэр, Галттай, Уялга голын хөндий эзэлдэг бөгөөд Хүдэр гол нь урсан хойд хилийн зааг болох Цөх голд цутган урсдаг байна. Баяжуулах үйлдвэрийн ойролцоо урсан өнгөрдөг гол мөрөн, гадаргын усан сүлжээ байхгүй болно.
4	Газрын доорх ус	Төсөл хэрэгжүүлэгч “Хүчин бүрэн” ХХК нь Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын даргын тушаалын дагуу гүний худаг гаргах зөвшөөрөл авч төслийн талбайд ажилчдын унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалттай ус ашиглах 2 гүний худгийг “Эрдэнэдриллинг” ХХК-аар гаргуулсан байна (Гүний худгийн паспортыг хавсаргав). Худгийн гүн нь 90 м, ундарга нь 3л/сек байна. Баяжуулах үйлдвэрийн технологид 340.000 м3 /жил, унд ахуй болон зам талбайн усалгаанд 2548 м3 /жил , нийт 70548 м3 /жил ус хэрэглэдэг байна.
5	Хөрсөн бүрхэвч	Тухайн орчны хөрсний бүтэц үржил шимийн хувьд газар тариалан малын бэлчээрт тохиромжтой. Уулсын өндөр хэсгээр уулсын цэвдэг чандруулаг, зарим газраа ширэг тайгын хөрс, зарим хэсэгт хар шороон хөрстэй байна. Энэ хэсэгт чийг, дулааны нөхцөл нилээд тохиромжтой учраас хөрсөнд органик бодисын задрал эрчимтэй явагдах бололцоо бүрдэж байна. Өөрөөр хэлбэл хөрс үүсвэрийн нөхцөл нь чийг дулааны хангамжийн аятай нөхцөлд явагддаг. Уулын ойн бараан болон ердийн хар хүрэн хөрс нь өвлийн улиралд 1.5-2.5 м хүртэл гүн хөлдөж хавар–зуны эхэн үед түргэн гэсдэг тул хур борооны үеэр хөрсөнд улиралын цэвдэг байдаггүй. Уулын хар шороон хөрстэй адил үе үе нэвт норж угаагдах чийгийн горим зонхилох боловч уулын өвөр хажуу дээрх сайр чулуурхаг нимгэн хөрс жил бүр нэвт норж (тэр ч байтугай зарим жил ургамлын ургалтын хугацаанд хэдэн удаа нэвт чийглэгдэж) угаагдлын

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		чийгийн горимтой байдаг тохиолдол ч бий. Үүнээс болоод уулын хүрэн шороон хөрсний дотор карбонатгүй хөрс бас цөөнгүй тохиолддог.
6	Амьтны аймаг	Хандгай, баавгай, шилүүс, бор гөрөөс, зэрлэг гахай, буга, хүдэр, үнэг, чоно, хярс, булга, ондатр, тарвага, зурам, өмхий хүрнэ, үен, дорго, нохой зээх зэрэг ан амьтад агнуурын болон нүүдлийн хун, тогоруу, зэрлэг нугас, галуу, ногтруу, хур, сойр, ятуу, ангир зэрэг олон төрлийн жигүүртэн шувууд элбэгтэй. Бэсрэг атаахай, асгасны огдой, дааган атаахай, тавшгар атаахай хэвийн. Жирх, ойн хүрэн оготно, улаан оготно, ойн булга, солонго, шилүүс, марал буга элбэг. Тарвага, хэргэлзэй оготно элбэг, урт сүүлт зурам хэвийн.
7	Ургамлын аймаг	Ургамлын нөмрөгийн хувьд бэсрэг уулын энгэр, хажуу, хормой, бэл хөндийн зүр өвст хээр болон алаг өвст үетэнт уулын нугархаг хээр зонхилно. Уулын ар хормой сувгийг дагаж 1-2 м 15 өндөртэй жижиг улиангар болон хусан төгөл, холимог байдлаар тархсанаас гадна голын урд талаар ус хагалбар дагаж бага хэмжээний төгөлүүд тохиолдоно. Төсөл хэрэгжүүлэгч нь одоогийн байдлаар баяжуулах үйлдвэрийн зориулалтаар нийт 2.3 га талбайд үйлдвэрийн болон бусад туслах байгууламжуудыг барьж байгуулснаар уг 2.3 га талбайн ургамлан нөмрөг бүрэн устаж, харин тээврийн хэрэгслийн болон хүний хөл хөдөлгөөний улмаас 0.1 га талбайн ургамлан нөмрөг нь талхлагдан доройтжээ.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлалын дагуу төслийн эерэг ба сөрөг нөлөөллийн үр дүнг тооцон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлээ. Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ болон бууруулах боломжгүй зарим сөрөг нөлөөлөл;
2. Байгаль орчны төлөв байдлыг сайжруулах боломжийг илрүүлэх;
3. Одоо байгаа бодит мэдээлэл, орхигдсон болон тодорхой бус байгаа мэдээллүүдийг тодорхойлох;

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд төслөөс үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд мөн төслийн үйл ажиллагаанаас хамааран олон шинж чанартай шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг тодорхойлон эдгээрийг бууруулах арга хэмжээг хамтад нь авч үзэн судлахыг шаарддаг. Төслийг хэрэгжүүлэхэд үнэлгээний үр дүнг үндсэн үзүүлэлтүүдээр авч үзэн зохих арга зүйг оновчтойгоор сонгон үнэлэх нь туйлын ач холбогдолтой. Төслөөс байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд:

1. Төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрээс байгаль орчин ба нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөлөл болон байгаль орчны бүрэлдэхүүнд нөлөөлөх хэмжээ, түүний тархалт;
2. Нөлөөллийг тодорхойлох ба тайлбарлах;
3. Нөлөөллийн хэмжээ, шинж чанарыг тооцоолж, судлан дүн шинжилгээ хийж, түүнийг бууруулах, арилгах, арга хэмжээг тодорхойлон гаргасан зөвлөмж;

Нөлөөллийн тархалт болон нөлөөлөлд өртсөн газрын, шимт хөрс, ургамлын нөмрөг, хөрсөн бүрхэвч, усны нөөцийн хэмжээг суурь болгон ашиглав.

Төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход ерөнхий үнэлгээний ажлын цар хүрээг нь нэгтгэн нөлөөллийн үнэлгээ, ангилалтай нь хамтатган авч үзлээ. Нөлөөллийг 4 хэсэг болгон дүгнэсэн. Үүнд:

1. Нөлөөллийн шинжээр
2. Нөлөөллийн үр дагавраар
3. Нөлөөллийн цар хүрээ, өртөлтийн хугацаа
4. Байгалийн нөхөн сэргээгдэх боломж, нөхөн сэргээгдэх байдал.

Нөлөөллийн дүн шинжилгээг суурь судалгааны материал болон судлаачдын мэдлэг туршлагад тулгуурлан хийлээ. Нөлөөллийг оноогоор үнэлэхэд дараах, томъёог ашиглав:

Нөлөөллийн нийлбэр оноо = $C*(Di+S+O+E+Du+R)$

Үүнд:

- C - Нөлөөллийн шинж; S- Ач холбогдол;
- O - орчинд үзүүлэх эрсдэл; E- Хамрах хүрээ;
- Du-үргэлжлэх хугацаа; R - Нөхөн сэргээгдэх.
- Di- доройтол

Нөлөөллийн ангилал онооны үнэлгээг Хүснэгт №4-д үзүүлэв. Нөлөөллийн шинж чанар, оноог (-1) сөрөг, (0) дунд зэргийн, эерэг (+1) гэж үзэх ба нөлөөллийн оноо нь 1 (бага)-ээс 3(их) хүртэл байна.

Хүснэгт 4. Нөлөөллийн үнэлгээний үзүүлэлт, оноо

№	bg	Үзүүлэлт ангилал	Нөлөөллийн оноо		
			(1)Эерэг	(-1) Сөрөг	(0) Дунд зэрэг
1	C	Шинж байдал	(1)Эерэг	(-1) Сөрөг	(0) Дунд зэрэг
2	Di	Доройтол	(3)Их	(2)Байнга	(1) Хязгаарлагдмал
3	S	Ач холбогдол	(3)Их	(2) Дунд зэрэг	(1) Бага
4	O	Орчинд үзүүлэх эрсдэл	(3)магадлал их	(2)Болох магадлалтай	(1) Бараг болохгүй
5	E	Хамрах хүрээ	(3)Бүс нутгийн хэмжээнд	(2) Орон нутгийн хэмжээнд	(1) Тодорхой газарт
6	Du	Үргэлжлэх хугацаа	(3) Байнга	(2)Тодорхой хугацаанд	(1) Богино
7	R	Нөхөн сэргээгдэх чанар	(3)Нөхөн сэргээгдэхгүй	(2) Зарим нь нөхөгдөнө, сэргээгдэнэ	(1) Бүрэн нөхөн сэргээгдэнэ

Нөлөөллийн үнэлгээний оноог нэгтгэн нөлөөллийн хэмжээг тогтоосон шалгуур үзүүлэлтийг хүснэгт №5-д үзүүлэв.

Хүснэгт 5. Нөлөөллийн үнэлгээ

Сөрөг нөлөөлөл		Эерэг нөлөөлөл	
Нөлөөллийн түвшин	Нийт оноо	Нөлөөллийн түвшин	Нийт оноо
Их	<-15	Их	<+15
Дунд	(-15, -9)	Дунд	(+9, +15)
Зөвшөөрөх	-9<	Бага	<+9

Төсөл хэрэгжиж буй орчны Байгаль орчны төлөв байдлын судалгааны үе шатанд орчны агаар, ус, хөрс, ургамал, амьтан, газрын хэвлийд нарийвчилсан дүн шинжилгээ хийлээ.

Орчны агаар, ус, хөрсний шинж чанарыг компанийн мэргэжлийн шинжээч нар, дээжүүдэд лабораторийн шинжилгээ хийлгэж үнэлгээ дүгнэлт өгсөн байна.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

“Хүчин бүрэн” ХХК-ийн “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх үүднээс уурхайн үйл ажиллагаатай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөлөө.

Тухайн төлөвлөгөөг БОАЖЯСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”-ийн болон БОННҮ-ний нэмэлт тодотголын тайлан, тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө зэргийг үндэс болгон боловсруулсан.

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

4.2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1 Агаарын чанар									
1	Төсөлд ашиглагдах машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Баяжуулах үйлдвэрт ашиглагдах бүх авто тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоо хийлгэх	Уурхайн бүх автомаши н	Ширхэг				Техникийн үзлэг оношилгооны хуваарь дагуу	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5364:2004
2	Төмрийн хүдрийг тээвэрлэх, ачиж буулгах зэрэг төслийн талбай дээр хийгдэх механик ажлын үед тоос, тоосжилт үүсэх	Эзэмшил талбай орчмын авто машины хөдөлгөөнд хяналт тавьж, хурдны хязгаар тогтоох,	Төслийн хүрээнд	-	-	-	YA3	2023 онд	
3		Эзэмшил талбайд олон салаа зам гарахаас сэргийлэх, шороон замын маршрут гаргаж тэмдэгжүүлэх;	Төслийн хүрээнд	-	-	-	200.0	2023 онд	
2 Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	Ус шавхан зайлуулалтын улмаас газрын доорх усанд хомстолд үүсэх	Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	YA3	2023 оны 2-р улиралд	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2		Ус ашиглах дүгнэлтийг Усны газраар гаргуулах .	Төслийн хүрээнд		-	-	YA3	2023 он	
3		Тухайн жил баяжуулах үйлдвэрт ашигласан усны төлбөрийг гэрээ болон ус ашиглах дүгнэлтэд заасны дагуу төлөх	Төслийн хүрээнд				YA3		
4		Технологит ашиглагдах 2 худгийн тоолуурын бүрэн	Төслийн хүрээнд				YA3		

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		бүтэн байдалд хяналт тавьж ажиллах							
5		Хаягдлын сан болон эргэлтийн усан сангаас нэвчилт болон халилт үүсэхээс сэргийлэх.					ҮАЗ		
Хөрсөн бүрхэвч									
1	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Машин механизмын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг бетон хучилттай талбайд хийх	Засварын талбайд				ҮАЗ	2023	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
2		Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Баяжуулах үйлдвэрийн талбайд				100.0	2023	
		Нийт					300.0		

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

1.1 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Хүчин бүрэн” ХХК-ийн баяжуулах үйлдвэрийн зориулалтаар ашиглаж буй 4.0 га талбайд үйл ажиллагаа явуулж байна. Эзэмшил талбайн 0.8 га талбайд нь үйлдвэрийн барилга байгууламж болон бусад туслах байгууламжууд, 1.5 га талбайд хаягдлын сан байгуулсан ба бусад талбай хүний үйл ажиллагаа болон техникийн нөлөөгөөр бага зэрэг эвдрэлд өртөнө. Тухайн талбайд нөхөн сэргээлтийн ажил төсөл үргэлжилж байх хугацаанд хийгдэхгүй ба баяжуулах үйлдвэр хаагдсаны дараа нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ. Иймд бид эзэмшил талбайд ногоон байгууламж үүсгэх зорилгоор жил бүр модлог ургамал болон мандлын цэцэг тариалж байна.

Хүснэгт 7. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Баяжуулах үйлдвэрийн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Хаягдлын сангийн талбай, баяжуулах үйлдвэр болон уурхайн тосгон орчмын талбайд	500 шихрэг мод тарих	-		2200.0	2023 он	MNS 5916:2008
	Нийт					2200.0		

1.2 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанд өртөх газар нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхит ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй үлдэх газарт хамаарахгүй тул биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг гүйцэтгэх шаардлагатай төсөлд үл хамаарна. /БОННУ-ний тайлан 2018/

1.3 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн эзэмшил талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй. Уурхай нь үйл ажиллагаа явуулж дууссаны дараа уурхайн хаалт болон нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ. /БОННУ тайлан 2018/

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

1.4 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр”-ийн орчимд түүх соёлын дурсгалт зүйлс байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлсийг хөндөх, түүнд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй тул БОМТ-нд түүх соёлыг хамгаалах арга хэмжээ тусгагдаагүй болно. Харин төслийн үйл ажиллагааны үед түүх соёлын дурсгалт зүйлс, булш, бунхан хирэгсүүр, археологи, палентлогийн зүйлс илрэх тохиолдолд соёлын өвийг хамгаалах үүднээс үйл ажиллагааг зогсоож, хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандаж мэдэгдэл хүргүүлнэ.

1.5 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Осол эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргээх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний, цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1. Хөдөлмөр хамгаалал								
1.1	Төслөөс гэнэтийн аваар осол, хөдөлмөр хамгааллын зөрчил илрэх	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Нийт ажилчид	-	-	Үйл ажиллагааны зардал	2023 он	
1.2		Ажил эхлэхээс өмнө хөдөлмөр хамгааллын заавар зөвлөгөөг өдөр бүр өгч байх	Нийт ажилчид			Үйл ажиллагааны зардал	2023 он	
2. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх								
2.1	Төслийн үйл ажиллагаанд техникаанд зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах Аянга цахилгаан, хэт халалт, хээрийн түймэр, гэнэтийн хүчтэй	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байдалд байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, түүний бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах.	Уурхайн тосгон, Тэсрэх материалын агуулах, ШТС	2		500.0	2023 он	MNS5078-2001, MNS 5390:2004,

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах							
3. Байгалийн аюул гамшиг								
3.1	Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшиг, аваар осол, гал түймрийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах				500.0	2023 он	Гамшгаас хамгаалах тухай хууль,
4.								
		Нийт				1000.0		

1.6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	Хог хаягдлын гэрээг Хүдэр сумын ЗД-тай байгуулах төлбөр төлөх	Төслийн хэмжээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2023 оны 4-р улиралд	Хог хаягдлын тухай хууль
2	Хатуу болон шингэн хог хаягдал	Ахуйн гаралтай хог хаягдлын ангилан ялгаж байх	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2023 он	
3		Ангилан ялгасан хог хаягдыг улиралд нэг удаа зөвшөөрсөн цэгт хүргүүлж байх	Төслийн хүрээнд	-	-	-			
4		Ахуйн хог хаягдлын цэг болон нүхэн жорлон бие засах газруудыг тогтмол ариутгаж байх	Төслийн хүрээнд	-	-	-			
5		Хийсч тархсан болон үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвших	Эзэмшил талбай болон						

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

			түүний ойр орчимд						
6	Аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган төслийн талбайд 150 хоног хадгалан дахин ашиглах цэгт хүргүүлж байх	Засварын газарт	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2023 он	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
		Нийт					ҮАЗ		

1.7 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулав.

Сэлэнгэ аймгийн Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчны шинжилгээний төв лабораторитой хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах.

Хүснэгт 10. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр


№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								
1.1	Хүхэрлэг хий (SO2) Азотын давхар исэл (NO2) Нийт тоосонцор	Баяжуулах үйлдвэрийн дотор тал болон салхин доор	2023 оны 10 сард	2		400.0		MNS5061:2001 MNS3113:1981 MNS0017.2.5.12:89 88
Хөрсөн бүрхэвч								

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

2.1	Ялзмаг, урвалын орчин (рН), давсжилт, карбонат (CaCO3), хөдөлгөөнт кали (K2O), хөдөлгөөнт фосфор (P2O5), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Хөрсөнд агуулагдах хүнд металл	Үйлдвэрийн орчим, Хаягдлын сан, эрүүл талбай	2023 оны 10 сард	3		400.0		MNS 2305-94 MNS 3298-1991 MNS 5850:2008
Усан орчин								
	Ca, Mg, Cl, SO4, NO2, NO3, NH4, HCO3, Fe, As, Na, K, Cd, Cu, Pb, Zn, Cr, Ni, Ag, Al, B, Ba, Mg, Mn, Se, Sr, Mo, Co, Be, Sb, Ca-ийн агууламж, амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар,	Хаягдлын сан, Эргэлтийн усан сан, гүний худаг-2	2023 оны 10 сард	4		800.0		MNS0900:1992 MNS3935:1986 MNS3936:1986 MNS4432:1997 MNS3934:1986 MNS5667-2:2001 MNS4867:1999
		2 гүний худгийн усны түвшин хэмжих	2023 оны 10 сард	2		400.0		
Эрүүл мэндийн хяналт								
	Ажилчдын эрүүл мэнд	Нийт ажилчдыг эрүүл мэнийн үзлэгт хамруулах	2023 он	1		ҮАЗ	Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах	
						2000.0		

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Зураг 4. ОХШХ-ийн дагуу шинжилгээ авах цэгүүдийн байршил



**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

1.8 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариусан албан тушаалтан	Тайлбар
			2023 он				
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7	Сар 8.9.10.11		
1	2	3	4	5	6	7	
1	БОХ-3 мэдээ болон тайлан төлөвлөгөөг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэхэд хяналт тавих	-			x	Захирал	
2	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн томилон ажиллуулах	-			x	Захирал	
3	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулах	ҮАЗ			x	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
4	2023 оны БОМТөлөвлөгөө боловсруулах	ҮАЗ			x	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
	Нийт	ҮАЗ					

1.9 Тухайн жил байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.

Хүснэгт 12. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Хүдэр сумын багийн иргэд	ИНХ-д танилцуулах уулзалт	2023 онд хийгдсэн ажил	4 - р улирал	200.0	Уурхайн дарга	Багийн төв

**Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

						Байгаль орчин хариуцсан ажилтан	
2	Сэлэнгэ аймгийн байгаль орчны газар	БОМтайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу боловсруулж Аймгийн байгаль орчны газарт хүргүүлэх цаасан хэлбэрээр болон файл хэлбэрээр, уулзалт	2023 оны биелэлтийн тайлан 2023 оны БОМтөлөвлөгөө	2023 оны 10-р сар 15-аас 11-р сарын 1	100.0	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Сэлэнгэ аймаг
3	Төрийн захиргааны төв байгууллага БОАЖЯ-ны ХБОБНУГ	БОМтайлан, БОМтөлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон Файл хэлбэрээр	БОМтайлан дүгнэх хуудсын хамт БОМтөлөвлөгөөг орон нутгийн саналын хамт	2023 оны 12 сарын 15 аас өмнө	100.0	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	УБ хот
	Нийт				500.0		

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт орших “Төмрийн хүдэр баяжуулах үйлдвэр” төслийн
2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Мэдээллийн төрөл	Нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	300.0
2	Нөхөн сэргээлтийн зардал	2200.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	-
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний төсөв	1000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв	Үйл ажиллагааны зардал
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	500.0
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	Үйл ажиллагааны зардал
8	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	2000.0
	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	6000.0